



## ЭМ ЗҮЙЧ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Дангаар болон бусадтай хамтран 3-аас доошгүй өгүүлэл, илтгэл хэлэлцүүлж хэвлүүлсэн байх;
2. Ажиллах хугацаандаа 3-аас доошгүй мэргэжигчийг дагалдуулан сургаж, дадлагажуулсан байх;
3. Ард иргэдэд эмийн зохистой хэрэглээний талаар сургалт, сурталчилгаа явуулсан байх;
4. Мэргэжлийн чиглэлээр зохион байгуулагдсан хурал, семинарт оролцсон байх;
5. Мэргэжлийн холбооны үйл ажиллагаанд идэвх санаачлагатай оролцдог байх.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Эм зүйч нь дангаар болон бусадтай хамтран 4-өөс доошгүй өгүүлэл, илтгэл хэлэлцүүлж хэвлүүлсэн байх;
2. Ажиллах хугацаандаа 4-өөс доошгүй мэргэжигчийг дагалдуулан сургаж, дадлагажуулсан байх;
3. Шинэлэг арга технологи нэвтрүүлсэн байх;
4. Ард иргэдэд эмийн зохистой хэрэглээний талаар сургалт, сурталчилгаа явуулсан байх;
5. Мэргэжлийн чиглэлээр хурал, семинар зохион байгуулах, зохион байгуулах ажлын хэсэгт оролцсон байх;
6. Мэргэжлийн холбооны үйл ажиллагаанд идэвх санаачлагатай оролцдог байх.

**ЗӨВЛӨХ** зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Эм зүйн чиглэлээр удирдах ажлыг 5-аас доошгүй жил хийсэн байх;
2. Эм зүйч нь дангаар болон бусадтай хамтран 5-аас доошгүй өгүүлэл, илтгэл хэлэлцүүлж хэвлүүлсэн байх;
3. Ажиллах хугацаандаа 6-аас доошгүй мэргэжигчийг дагалдуулан сургаж, дадлагажуулсан байх;
4. Шинэлэг арга технологи нэвтрүүлж, үр дүнд хүрсэн байх;
5. Ард иргэдэд эмийн зохистой хэрэглээний талаар сургалт явуулсан байх;
6. Мэргэжлийн чиглэлээр хурал, семинар зохион байгуулах, зохион байгуулах ажлын хэсэгт оролцсон байх;
7. Мэргэжлийн холбооны үйл ажиллагаанд идэвх санаачлагатай оролцдог байх.